



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

**БАТЛАВ.**

САЛБАРЫН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА  
*/Албан тушаал/*



С.СҮНЧИН  
*/Гарын үсгийн тайлал/*

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 10100/07

Улаанбаатар хот

Г  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ГАЗРЫН  
БАЙРШИЛ ТОГТООХ, ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОХ,  
АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД ЭРҮҮЛ АХУЙН  
УРЬДЧИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ

Нэг. Зорилго, үндэслэл

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 11.1.3, 4.1.43 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг үндэслэн барилга байгууламжийг барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, үнэлгээ дүгнэлт өгөхөд хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Хяналт шалгалтын төрөл

Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх

Гурав. Хяналт шалгалтын арга

3.1. Шалгалтыг баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, үзлэг хийх, тайлбар авах, дээж авч шинжилгээнд хамруулах зэрэг аргаар хийж гүйцэтгэнэ.

3.2. Барилга байгууламжийн газар олголтын шатанд хяналт хийхдээ барилга барихаар төлөвлөж буй газарт тухайн барилгыг барихад холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагад нийцэж буй эсэхийг шалгаж, улсын байцаагчийн дүгнэлт гаргана.

141623010

3.3. Барилга байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж улсын байцаагчийн дүгнэлт гаргана.

3.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах үед эрүүл ахуйн хяналтын чиглэлээр илэрсэн зөрчлийг улсын комиссын хурлын тэмдэглэлд тусгуулж, зөрчил дутагдлыг бүрэн арилгасан тохиолдолд үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд тэмдэглэж баталгаажуулна.

Дөрөв. Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр

4.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зөвшилцөх, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн хяналт хийж дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийнэ.

4.2. Барилга байгууламжийн газар олголтын шатанд эрүүл ахуйн хяналт хийхдээ хот тосгоны хөгжлийн ерөнхий ба хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зориулалт, хот тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл, үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ хангагдах байдал, барилга хоорондын зай хэмжээ, нарны тусгал, инженерийн байгууламжийн шийдэл, усан хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийн байршил, төлөвлөж буй барилгын эдэлбэр газар болон өргөтгөх талбай зэргийг харгалзан үзэж дүгнэлтэд тусгана. Шаардлагатай тохиолдолд барилга байгууламж барихаар төлөвлөж буй талбайд хөрс, орчны агаарын шинжилгээ хийлгэж болно.

4.3. Барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийх явцад шаардлагатай бол орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамжийн зураг төсөл хийлгэж үнэлгээ өгнө.

4.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үеийн хяналт хийх шатанд барилга байгууламж нь батлагдсан зураг төслийн дагуу баригдсан эсэх, холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулсан тохиолдолд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд гарын үсэг зурж, баталгаажуулна.

4.5. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын 5.5-д заасны дагуу усны дээжинд лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргана.

4.6. Орон сууц, сургууль, хүүхдийн байгууллага, эмнэлэг, албан байгууллага болон хүн тогтмол ажилладаг үйлдвэр, үйлчилгээний барилгыг ашиглалтад хүлээн авахад барилгын дотор заслын материалаас дотоод орчинд ялгаруулах дэгдэмхий органик нэгдэл, хүнд металл зэргийг тодорхойлох шинжилгээг хийлгүүлж үнэлгээ өгнө.

Тав. Хяналт шалгалт хийх бүрэлдэхүүн

Хяналт шалгалтыг орчин, хүнс, хүүхэд, халдвар судлалын асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Хяналт шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Хяналт шалгалтыг 2023 оны 1-4 дүгээр улиралд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Хяналт шалгалтын дүнг танилцуулах.

7.1. Хяналт шалгалтын дүнг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж, улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Салбарын хяналтын газарт ирүүлнэ.

7.2. Эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийсэн шалгалтын дүн мэдээг тухай бүрт нь шилэн хяналтын цахим системд бүртгэнэ.

7.3. Хяналт шалгалтын дүн мэдээг чиглэл бүрээр улсын ахлах байцаагч нар нэгтгэж, хяналтын газрын удирдлагад танилцуулна.

